МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
Жинст баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82093
Утас: 7048-4004, Факс:7048-3360

2025. 01. 30 № 1/140

танай _____-ны № _____-т

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
САНГИЙН ГАЗАРТ

Санхүү, Төрийн сангийн хэлтсийн 2024 онд хийсэн дотоод хяналтын тайланг хүргүүлэв.

Хавсралт .... хуудастай.

Г.ЧИНБАТ

8200059072

Говь-Алтайский аймак
Алтайская сомонная администрация

Монгол Улс, Говь-Алтай аймаг, Алтай сомон, 82093,
Администрацийн хаяг, гудамжны нэр

Утас: (976) 7048 3360, факс: (976) 7048 4004,
Цахим хуудас: www.govi-altai.gov.mn
Цахим шуудан: info@govi-altai.gov.mn,

Дугаар ____ өдөр ____ он ____ сар

Танай ____ оны ____ сарын ____ өдрийн ____ дугаар албан бичигт

Дээрх асуудлаар Алтай сомоны Засаг даргын Тамгын газраас
дараах зүйлсийг мэдэгдэж байна.

Сомоны Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Ганбаатар

Сомоны Засаг даргын Тамгын газрын ахлах мэргэжилтэн Ц.Ганхуяг

Сомоны Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн Ц.Ганзориг

Сомоны Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн Ц.Ганцэцэг

Сомоны Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн Ц.Ганчимэг

Сомоны Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн Ц.Ганболд

Сомоны Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн Ц.Ганбаяр

Сомоны Засаг даргын Тамгын газрын

Төрийн сангийн үйл ажиллагааны
дотоод хяналтын зааврын
Наймдугаар хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ДОТООД ХЯНАЛТЫН ТАЙЛАН

Төрийн сангийн үйл ажиллагаанд хууль, журам, зааврыг мөрдөж, шат шатанд нь зохих хяналттайгаар явуулж байгаа эсэхийг магадлан, эрсдэлийн үнэлгээ хийж цаашид гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч үйл ажиллагааг сайжруулахад оршино.

Аймгийн нэр: Говь-Алтай аймаг
Сумын тоо: 18 сум, 2 тосгон
Төлөвлөгөөт дотоод хяналтад хамрагдсан дүүрэг/сумын тоо: 5
Төлөвлөгөөт дотоод хяналт хэрэгжүүлсэн албан тушаал: Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн
Төлөвлөгөөт дотоод хяналт хэрэгжүүлсэн албан тушаалтны нэр: Ц.Баярсайхан
Төлөвлөгөөт бус дотоод хяналтад хамрагдсан дүүрэг/сумын тоо: 18 сум, 2 тосгон
Төлөвлөгөөт бус дотоод хяналт хэрэгжүүлсэн албан тушаалтан: Ч.Дариймаа

№		Хууль, эрх зүйн заалтууд	Дотоод хяналтын тайлан
1	Хамарсан хүрээ: 18 сум, 2 тосгон		
2	Хийгдэх ажлууд: Сумдын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд илэрсэн нийтлэг зөрчил, өгсөн үнэлэлт, дүгнэлт зөвлөмжийн талаар Үүнд: 1.Төрийн сангийн төлбөр тооцооны талаар 2.Төсвийн зарлагын талаар 3.Төсвийн орлого бүрдүүлэлтийн талаар		
3	Ерөнхий мэдээлэл: Тус онд аймгийн бүх сумдын төрийн сангийн нэгжүүдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналтыг хэрэгжүүлэхээр сумдад ажиллах хуваарь, “Нэгдсэн удирдамж”-ийг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан 2024 оны 09 дүгээр сард төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн Ц.Баярсайхан хуваарийн дагуу ажиллан сум бүрд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллав.		
4	**Зөвлөмжүүд:**		
1.Төрийн сангийн төлбөр тооцооны талаар:			
1.1	Төсвийн байгууллагын өглөг, авлагын мэдээг сар бүр баталгаажуулан авч ЗГСУМС /Freebalance/-д үнэн зөв оруулж байх;	Төсөв захирагч, санхүү бүртгэлийн ажилтан албан хаагчид “Төсвийн тухай хууль”-ийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах;	Аймгийн төвийн 7, сумдын 110 төсвийн байгууллагын өглөг, авлагын мэдээг сар бүр баталгаажуулан авч ЗГСУМС /Freebalance/-д үнэн зөв оруулсан.
1.2	Төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор хүлээн авах, архивын нэгж үүсгэж байх;	Төсөвт байгууллагын нягтлан бодогчид төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.21 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах;	Төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор хүлээн авч баталгаажуулан архивын нэгж үүсгэн ажиллаж байна.
1.3	Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, “Төрийн хэмнэлтийн тухай хууль” болон холбогдох бусад хууль, журам, баталсан төсөв, зарцуулалтын эрхийн хүрээнд төлбөр тооцоог хянан баталгаажуулах	Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”, “Төрийн хэмнэлтийн тухай хууль” болон холбогдох бусад хууль, журам, баталсан төсөв, зарцуулалтын эрх	Төрийн сангийн системд 2024 онд 64,038 ширхэг гүйлгээ хийгдсэн нь сард дунджаар 5,330 ширхэг буюу өдөрт дунджаар 242 ширхэг гүйлгээг төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн хянаж, дотоод хяналтын мэргэжилтэн баталгаажуулан ажилласан байна. Төсөвт байгууллагаас эрсдэлтэй гүйлгээ гарахаас сэргийлж дотоод хяналтын мэргэжилтэн, төлбөр тооцооны мэргэжилтнүүд 2,208 ширхэг гүйлгээг хууль журам зааврын дагуу хянан буцааж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

1.4	Бэлэн мөнгөний картын дансаар үндэслэх санхүүгийн анхан шатны баримт дутуу, баталгаажаагүй тушаал шийдвэрээр бараа материал бусад төлбөрийг бэлнээр гаргахгүй байх;	-Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам” -Төрийн сангийн үйл ажиллагааны журмын “маягт-ТТ-2А” дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир спортын газрууд нь арилжааны банканд төлбөрийн картын данстай. Аймгийн Засаг даргын Тамгын газрын байгууллагын төлбөрийн картын дансыг тус байгууллагын нярав эзэмшин зарлагын гүйлгээг гүйцэтгэж байгаа бөгөөд 2024 онд 125 ширхэг гүйлгээгээр 485.5 сая төгрөгийг бэлэн мөнгөний картын дансаар дамжуулан гаргасан байна. Иймд тус байгууллагын 5315620466 тоот дансыг хаалгах талаар чиглэл хүргүүлсэн боловч хаагаагүй байна. Баримт дутуу материалыг нөхөж санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлсэн.
1.5	Зарлагын гүйлгээ хийхийг хориглосон заалт бүхий төлбөр тооцоог гүйцэтгэхгүй байх;	Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.5.6 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах	Системээр аймгийн төрийн сангийн нэгжүүдийн төлбөр тооцоо болон санхүүгийн анхан шатны баримтад хяналт тавин ажилласан.
1.6	Гарын үсгийн баталгааг журмын дагуу иж бүрдлийг хангуулж баталгаажуулах албан тушаалтан өөрчлөгдсөн тухай бүр шинэчлэн “Эрхийн бүртгэлийн сан”-д мэдээллийг оруулж байх;	Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.3, 3.4.4 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах	Байгууллагын дарга, нягтлан бодогч нь солигдсон 19 төсөвт байгууллагын 42 дансны гарын үсгийн баталгааг гаргуулан авч журмын хэрэгжилтийг ханган ажиллалаа. Мөн Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.3-д заасны дагуу бүх Төсвийн байгууллагуудын бүртгэлийн дансны гарын үсгийн баталгааг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу үйлдэн шинэчлэн авсан.
1.7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах;		Төсвийн гүйцэтгэл, өр авлагын мэдээг сар бүрийн 02-ны дотор хүлээн авч,

		Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	хянан баталгаажуулж, өөрийн орлого, нэр данс зөрүүтэй зардал, өр авлагыг программд шивж оруулан, төсвийн гүйцэтгэл өр авлагыг шилэн дансанд тухай бүр мэдээлж хэвшсэн. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 98 хувьтай байна.
1.8	Сумын санхүүгийн албаны дарга болон төрийн сангийн мэргэжилтэн ээлжийн амралт авах, чөлөөтэй, ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн сангийн программд нэвтрэх эрх, нууц кодоо “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-ын батлагдсан хавсралт маягтыг бөглөж удирдлагадаа танилцуулан эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Сангийн сайдын 2014 оны 95 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-ын дагуу гүйцэтгэх	Гуулин, Баянтоорой тосгон, Жаргалан, Дарив, Төгрөг сумын санхүүгийн албаны дарга нар хуучин хэрэглэгчийн эрхээр ЗГСУМС/Freebalance/-д нэвтэрч байгаа нь “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-ыг зөрчиж байна. Иймд тухайн албан хаагчид төрийн албаны шалгалт өгч жинхлэн системийн эрхийг шилжүүлэн авах;
1.9	Төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлэн, тайланг бодит байдалд нийцүүлэн бичиж, эрсдэлийг үнэн бодитоор үнэлэн хугацаанд нь ирүүлэх;	Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”, төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй холбогдох журмын дагуу гүйцэтгэх	Төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг 18 сум 2 тосгон, аймгийн төрийн сан нийт төрийн сангийн 21 нэгжид 22 асуулга бүхий эрсдэл үнэлэх хуудсаар үнэлэхэд эрсдэл 1-5 буюу бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна.
2.Төсвийн зарлагын талаар:			
2.1	Орон нутгийн төсвийн байгууллагууд, сумдын санхүүгийн дэмжлэг, ОНХС, хөрөнгө оруулалтын төсвийн сар, улирлын хуваарийн дагуу аймгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулан мөнгөн хөрөнгийн тэнцвэрийг хангаж санхүүжилтийг олгох;	“Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 23, 24 дүгээр маягтын дагуу эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан олгох	Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/576 дугаар захирамжаар баталсан төсвийн сар улиралын хуваарийн дагуу санхүүжилт олгож байна. Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдан төсвийн байгууллага, сумдын санхүүгийн дэмжлэг, ОНТХО-н санхүүжилтийг дутуу олгосон. Жилийн эцсийн байдлаар сумдын санхүүгийн дэмжлэгийн

			86.9%, байгууллагуудад олгох санхүүжилтийн 82.7%, сумдын ОНХС-н санхүүжилтийн 95.6%-г олгосон байна.
2.2	Төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн эрхийг байгууллагын албан хүсэлт НТ-2 маягтын дагуу гаргуулан авч хэлтсийн даргад танилцуулан журмын дагуу аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн зарцуулах эрхийг нээж, аль төсвөөс санхүүжиж байгаагийн дагуу эх үүсвэрийг нь дотоод хяналтын мэргэжилтэн хүсэлтийг нь нээж, гүйлгээг дамжуулан ажиллах;	Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 19 дүгээр хавсралт, маягт-НТ-2	Төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн эрхийг байгууллагын албан хүсэлт НТ-2 маягтын дагуу гаргуулан авч хэлтсийн даргад танилцуулан журмын дагуу аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн зарцуулах эрхийг нээж, аль төсвөөс санхүүжиж байгаагийн дагуу эх үүсвэрийг нь дотоод хяналтын мэргэжилтэн хүсэлтийг нь нээж, гүйлгээг дамжуулан ажиллалаа.
3. Төсвийн орлого бүрдүүлэлтийн талаар:			
3.1	Төсвийн тухай хуулиар батлагдсан улсын болон орон нутгийн төсвийн орлогыг цаг хугацаанд нь татварын болон татварын бус орлогын нэр төрлөөр нь бүрэн төвлөрүүлэх	Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 23.5, 23.6, 23.7, 23.8, 23.9 дах заалтууд	Тайлант онд орон нутгийн төсөвт 40664.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 34415.6 сая төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 84.6 хувиар, улсын төсөвт 4179.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 4840.6 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 116 хувиар тус тус биелүүлсэн байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны
дотоод хяналтын зааврын
Есдүгээр хавсралт

ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Яам/ нийслэл/ аймаг/ дүүрэг/ сум/-ын нэр: Говь-Алтай аймаг
Дотоод хяналтын хэлбэр: Төлөвлөгөөт бус
Дотоод хяналт хэрэгжүүлсэн хугацаа: 2024.11.01-2024.12.31

	Дотоод хяналтаар өгсөн зөвлөмж	Зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний биелэлт (биелээгүй бол шалтгаан)	Авсан арга хэмжээ хангалттай эсэх (Тийм/Үгүй)
1	Төсвийн байгууллагын өглөг, авлагын мэдээг сар бүр баталгаажуулан авч ЗГСУМС /Freebalance/-д үнэн зөв оруулж байх;	Биелсэн	Тийм
2	Төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор хүлээн авах, архивын нэгж үүсгэж байх;	Биелсэн	Тийм
3	Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал	Биелсэн	Тийм

	ашиглах заавар", "Төрийн хэмнэлтийн тухай хууль" болон холбогдох бусад хууль, журам, баталсан төсөв, зарцуулалтын эрхийн хүрээнд төлбөр тооцоог хянан баталгаажуулах		
4	Бэлэн мөнгөний картын дансаар үндэслэх санхүүгийн анхан шатны баримт дутуу, баталгаажаагүй тушаал шийдвэрээр бараа материал бусад төлбөрийг бэлнээр гаргахгүй байх;	Биелсэн	Тийм
5	Зарлагын гүйлгээ хийхийг хориглосон заалт бүхий төлбөр тооцоог гүйцэтгэхгүй байх;	Биелсэн	Тийм
6	Гарын үсгийн баталгааг журмын дагуу иж бүрдлийг хангуулж баталгаажуулах албан тушаалтан өөрчлөгдсөн тухай бүр шинэчлэн "Эрхийн бүртгэлийн сан"-д мэдээллийг оруулж байх;	Биелсэн	Тийм
7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах;	Биелсэн	Тийм
8	Сумын санхүүгийн албаны дарга болон төрийн сангийн мэргэжилтэн ээлжийн амралт авах, чөлөөтэй, ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн сангийн программд нэвтрэх эрх, нууц кодоо "Засгийн газрын санхүүгийн	Гуулин, Баянтоорой тосгон, Жаргалан, Дарив, Төгрөг сумын санхүүгийн албаны дарга нар хуучин хэрэглэгчийн эрхээр ЗГСУМС/Freebalance/-д нэвтэрч байгаа нь "Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам"-ыг	Тийм

	удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам”-ын батлагдсан хавсралт маягтыг бөглөж удирдлагадаа танилцуулан эрсдэлээс урьдчилан сэргийлэх	зөрчиж байна. Иймд тухайн албан хаагчид төрийн албаны шалгалт өгч жинхлэн системийн эрхийг шилжүүлэн авах;	
9	Төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлэн, тайланг бодит байдалд нийцүүлэн бичиж, эрсдэлийг үнэн бодитоор үнэлэн хугацаанд нь ирүүлэх;	Биелсэн	Тийм
10	Орон нутгийн төсвийн байгууллагууд, сумдын санхүүгийн дэмжлэг, ОНХС, хөрөнгө оруулалтын төсвийн сар, улирлын хуваарийн дагуу аймгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулан мөнгөн хөрөнгийн тэнцвэрийг хангаж санхүүжилтийг олгох;	Биелсэн	Тийм
11	Төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн эрхийг байгууллагын албан хүсэлт НТ-2 маягтын дагуу гаргуулан авч хэлтсийн даргад танилцуулан журмын дагуу аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн зарцуулах эрхийг нээж, аль төсвөөс санхүүжиж байгаагийн дагуу эх үүсвэрийг нь дотоод хяналтын мэргэжилтэн хүсэлтийг нь нээж, гүйлгээг дамжуулан ажиллах;	Биелсэн	Тийм

12	Төсвийн тухай хуулиар батлагдсан улсын болон орон нутгийн төсвийн орлогыг цаг хугацаанд нь татварын болон татварын бус орлогын нэр төрлөөр нь бүрэн төвлөрүүлэх	Биелсэн	Тийм

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

ХЯНАСАН:

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Л.ХАШ-ЭРДЭНЭ

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ч.ДАРИЙМАА